

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН 100 ЧИГЛҮҮЛЭГЧ

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй Идэвхэжсэн2030 төслийн хүрээнд залуучуудын энтерпрайзинг ур чадварыг хөгжүүлэх Training of Trainers (ToT) буюу тогтвортой хөгжлийн чиглүүлэгч багш нарыг бэлтгэх “ЭНТЕРПРАЙЗИНГ ХӨДӨЛГӨӨН” сургалт, воркшопыг энэ сарын 8-10-ны өдрүүдэд цахим виртуал хэлбэрээр зохион байгууллаа.

Уг сургалтыг олон улсад хэрэгжиж буй сайн дурын залуучуудын хөдөлгөөн болох Ази Номхон далайн бүс нутгийн Youth Co:Lab-Movers төслийг Монголын хөрсөнд тохируулан загварчилж нийгэмд эерэг нөлөө үзүүлэх залуучуудыг чиглүүлэгчээр бэлтгэн чадавхжуулах, санаагаа ажил хэрэг болгох чадварыг хөгжүүлэх, аливаа арга хэмжээ, үйл ажиллагааг зохион байгуулах мэдлэг, ур чадварыг олгох замаар нийгмийн манлайлагч залуучуудын тоог нэмэгдүүлэх зорилгоор санаачлан хэрэгжүүллээ.

ЭНТЕРПРАЙЗИНГ ХӨДӨЛГӨӨН ГЭЖ ЮУ ВЭ?

Энтерпрайзинг хөдөлгөөн гэж нэрлэсэн учир нь дараа дараагийн чиглүүлэгч залуусыг сургах хүний нөөцийг тодорхой давтамжтайгаар, тасралтгүй бэлтгэх үйл ажиллагааг эхлүүлж, зорилтот бүлгийн залуусын идэвхижүүлэлтийг хийн зорилгынхоо төлөө суралцах, шинийг санаачлах замаар тэднийг хөдөлгөх, өнөөдөр байгаа цэгээсээ хөдөлсөн байх тасралтгүй шилжилт хөдөлгөөн гэдэг утгаар ...

СУРГАЛТЫН СЭДЭВ:

Сургалтын үндсэн хөтөлбөр нийт гурван өдөр үргэлжилсэн ба

- 1) Чиглүүлэгч, чиглүүлэгчийн үүрэг,
- 2) хөгжил, хөгжлийн тулгуур,
- 3) оролцоо,
- 4) энтерпрайзинг сэтгэлгээ, асуудлыг шинжлэх, шийдвэр гаргах,
- 5) арга хэмжээг (сургалт, уулзалт, эвэнт) төлөвлөх, зохион байгуулах,
- 6) бүлэгтэй ажиллах гэсэн нийт 6 багц сэдвээс бүрдсэн.

Эхний өдөр нь Тогтвортой хөгжлийн чиглүүлэгч гэж хэн бэ?, Сургалт, хөтөлбөр, арга хэмжээнд оролцогчидтой ажиллах арга зүй, зохион байгуулах хэлбэрүүд гэсэн сэдвээр явагдсан. Удаах өдөр нь Энтерпренер сэтгэлгээ буюу санаагаа бодитой хэрэгжүүлэх нь, Нийгмийн хөгжлийн үйл явц ба тулгуур ойлголтууд гэсэн сэдвээр явагдсан. Гурав дахь өдөр нь Арга хэмжээг зохион байгуулах аргачлал, Нийгмийн хөгжил дэх хувь хүний оролцоо гэсэн сэдвээр болсон.

АВАХ ҮР ӨГӨӨЖ:

Энэхүү хөтөлбөрөөр сүүлийн үеийн судалгаагаар Монголын залуучуудад шаардлагатай гэж тодорхойлогдсон топ 5 ур чадвар болох харилцаа хандлага, асуудал шийдвэрлэлт, багийн ажиллагаа, төлөвлөлт болон бүтээлч сэтгэлгээ, санаагаа хэрэгжүүлж ажил хэрэг болгох чадваруудыг хөгжүүлэх, Залуучуудын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн эвэнт арга хэмжээг бие даан зохион байгуулах суурь мэдлэг, ур чадвар олж авах юм.

ХЭН ХАМРАГДСАН:

Байгууллагын үүсгэн байгуулагчид, гүйцэтгэх захирлууд, хөрөнгө оруулагчид, манлайлагчид, бүх салбарын удирдлагууд

Тогтвортой хөгжлийн чиглүүлэгч бэлтгэх онлайн сургалтанд нийт 100 оролцогч бүртгүүлж оролцсон ба 53 төрийн албан хаагч, 13 коммюнити менежерүүд, 18 UB Volunteer буюу сайн дурын ажилтнууд, Орхон, Эрдэнэт аймгаас 16 оролцогч хамрагдсан байна.

Үүнээс 78 оролцогч буюу 78% нь эмэгтэй, 22% буюу 22 оролцогч нь эрэгтэй байна.

Нийт оролцогчдын 80% нь чиглүүлэгчийн сургалтанд хамрагдаж байгаагүй, 20% нь чиглүүлэгчийн сургалтанд хамрагдаж байсан байна.

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (НЗДТГ)
- Нийслэлийн Шинжлэх ухаан, Үйлдвэрлэл, Инновацын газар
- Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
- Орхон аймгийн Засаг Даргын Тамгын газар
- Орхон аймгийн Гэр бүл хүүхэд, залуучуудын газар

НИЙСЛЭЛИЙН ШИНЖЛЭХ УХААН, ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦЫН ГАЗАР